

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр, Лхагва гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

<b><i>Хуралдааны товч тэмдэглэл:</i></b>	1-4
<b><i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i></b>	5-8

---

<b><i>1. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i></b>	5
<b><i>2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг</i></b>	5-6
<b><i>3. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i></b>	6-7
<b><i>4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i></b>	7-8

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны  
04 дүгээр сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 33 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Ч.Хүрэлбаатар;  
Чөлөөтэй: Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд;  
Тасалсан: Ж.Батсуурь.

**Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 35 минутад хэлэлцэж дуусав

**Хоёр. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

*Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

**Г.Тэмүүлэн:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасны дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 14 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 47 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
11 цаг 33 минут.

### **ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Ганибалын Амартүвшин гишүүн, Хавдисламын Баделхан гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц бүрдсэн байна. Ингээд Төсвийн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 4 асуудал байгаа. 1 дүгээрт, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл эцсийн хэлэлцүүлэг, 2 дугаарт, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, Засгийн газраас өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, Засгийн газраас өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, 4 дүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл, гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай гэсэн энэ 4 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн төсөл болоод тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ингээд

Байнгын хорооны, Байнгын хорооноос эцсийн хэлэлцүүлэг дэмжигдсэн тэй холбогдуулаад тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн байна уу? Би өөрөө танилцуулчихъя даа. Тэмүүлэн, би өөрөө танилцуулъя. Ингээд тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

11.35 цаг

**Хоёр. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

2 дахь асуудал Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Энэ хаанаас гарч байгаа санал билээ? 1 дүгээр зүйл дээр байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн зүйл бүрээр нь санал хураалт явуулж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй

холбогдуулаад асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг орж ирсэн үү, байгаа юу?

Ажлын хэсэг орж ирсэн байна. Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунцэцэг дарга хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооноос хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад найруулгын бараг шинж чанартай, зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлдсэн байсан. Саналын томъёолол гүйцэт танилцсан байх тийм ээ, болохоор байна уу? Хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй саналын томъёолол ийм орж ирж байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасах гээд санал гаргасан миний бие гаргаад явъя, Их Хурлаас ажлын хэсгээс бас Байнгын хорооноос гаргаж байгаа санал байгаад байгаа. 2 дугаар зүйл нь энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан эмийн жагсаалтыг барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан системийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална гэснийг хасъя гэсэн саналтай байгаа. Энэ заалтыг хасахад тодорхой өөр хуулийн зөрчил үүсэх гэдэг юм уу, хийдэл гарах зүйл бол байхгүй тийм ээ, болж байна гэж ойлгох уу? Тэгээд дээгүүрээ болбол 1 дүгээр заалтаар болбол гепатитын Д вирус эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй л гэсэн ганцхан заалттай болох нь байна шүү дээ. 3 номер ажлын хэсэг.

**П.Оюунцэцэг:** Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль дээр бараа материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөөд, жагсаалтаа Засгийн газрын тогтоолоор баталдаг байсан. Одоо энэ маань өөрөө эмийнхээ шууд нэрээрээ хуульд орж байгаа учраас бид нар бас тэр жагсаалтын хүрээнд хасчих боломжтой гэж үзэж байна.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Тэгвэл болж байна гэсэн үг. Ингээд сая хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалт 68,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асууж, зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргах гишүүд байна уу? Алга байна. 3 дээр, 3 дээр саяын 2 дугаар зүйл байхгүй болсонтой холбогдуулаад төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гээд би өөрөө гаргаад явчихъя. Энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,6 хувиар юм байна шүү. Түрүүн бас буруу уншсан байна. 63,6 хувиар дэмжигдлээ санал. Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин гишүүн танилцуулах уу, Сандаг-Очир гишүүн танилцуулах уу? Сандаг-Очир гишүүн танилцуулъя. Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

11.40 цаг

**Гурав.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

3 дахь асуудалдаа оръё. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүн танилцуулснаар байгаа. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг сайд хүрэлцэн ирсэн байна. Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, Эрүүл мэндийн

яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга Аюурзанын Өнөржаргал нар хүрэлцэн ирсэн байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн зүйл бүрээр нь санал хураалтыг явуулж эхэлье. Хуулийн төсөл 3 зүйлтэй байгаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асууж, санал гаргах, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Энэ бас адилхан юм байна. Энэ тэгэхээр түрүүн бас нөгөө Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуультай яг адилхнаар төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг бас гаргаж байгаа юм байна, бас болно гэж ойлгож байгаа тийм ээ? Ажлын хэсэг. Нэмэгдсэн өртгийн албан татвар дээр. Засгийн газрын ажлын хэсэг саяын нөгөө энэ 2 дугаар зүйлийг хасах, 2 дугаар зүйл хасагдсантай холбоотой 3 дугаар зүйлийг 2 гэж өөрчлөх гэдэгтэй болбол ойлгож байгаа, болж байна гэж ойлгож байгаа тийм ээ? 3 номерын микрофон Оюунцэцэг дарга.

**П.Оюунцэцэг:** Мөн адил бараа материалын нэр тодорхой байгаа учраас 2 дугаар заалтаа хасаж байна.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа танд. Ингээд Байнгын хорооноос гаргаж байгаа 2 дугаар зүйлийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал 63,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бас мөн адил саналтай байгаа Байнгын хорооноос. Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх санал

гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн гээд. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 63,6 хувиар дэмжигдлээ. Санал хураалтыг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна. Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

11.44 цаг

**Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/**

4 дэх асуудалдаа орёе. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар тогтсон байгаа.

Ингээд та бүхэнд Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг бас танилцуулъя. Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай гээд миний бие бас өөрөө энийг ахлаад явъя гэсэн саналтай байгаа. Ажлын хэсгийн гишүүдэд Булгантуяа болон Пүрэвдорж гишүүн нарыг оролцуулъя гэсэн саналтай байна. Нэмж гишүүд бас оролцож болно. Ингээд 1 дүгээр зүйлээр болбол ажлын хэсгийн бүрэлдэхүүнээ байгуулж байна 3 хүнтэйгээр. 2 дугаар зүйл дээр нь ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгуулагаас мэргэжлийн хүмүүсийг



татан оролцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид зөвшөөрсүгэй гэсэн ийм Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэгт нэмж орох саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Наашаа аваад өгчих. 63,6 хувиар дэмжигдлээ.

Дахиад энэ асуудалтай холбогдуулаад ажлын хэсэг бас нэг зүйлийг гаргуулаад авчихъя гэсэн зүйл байгаа. Дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах гэдэг, дүгнэлт гаргах энэ шаардлага байна гэж үзээд, энэ Дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийг үндэслэж, дараа долоо хоногоос ер нь Улсын Их Хурлын, Гаалийн тариф болоод Гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл маань одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа талаар эрх зүйн дүгнэлт гаргуулах шаардлагатай байна. Тэгээд энийг болбол бас Байнгын хорооноос бас гаргуулья гэсэн саналын томъёоллоор бас санал хураалтыг явуулчихъя.

Ингээд Засгийн газарт болбол албан бичгээр хүргүүлээд, хууль зүйн дүгнэлтийг болбол ажлын хэсэгт гаргуулаад авъя гэсэн ийм саналтай байгаад байгаа юм. Ингээд хууль зүйн дүгнэлт гаргуулах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 63,6 хувиар дэмжигдлээ. Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Мөн байнгын хорооноос энэ асуудалтай холбогдуулаад эрх зүйн дүгнэлт гаргуулах асуудлаар зарчмын санал хураалгаж дэмжигдлээ.

Ингээд Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Ажлын хэсэг болоод Байнгын хороон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

